

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.07 №25 (25)

ҮЙЛ ЯВДАЛ

ОФИЦЕРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭРГЭШИЛ, УР ЧАДВАР, ЁС ЗҮЙН ТҮВШИНГ ТОГТООНО



Батлан хамгаалах салбар сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах, төрийн албан хаагчийн ёс зүйн түвшинг дээшлүүлэх талаар эрчимтэй ажиллаж байна.

Нэн түрүүнд Зэвсэгт хүчний офицерын бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар, ёс зүйн түвшинг тогтоох үзлэгийг 2021 онд зохион байгуулж, офицер нэг бүрийн албандаа хандах хандлагыг өөрчлөн сайжруулах, цэргийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Батлан хамгаалахын сайдын тушаал гарч бэлтгэл ажлыг хангаж байна. Хоёрдугаарт, Батлан хамгаалахын сайдын дэргэд Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Иргэний зөвлөл”-ийг байгуулахаар болж дүрэм, ажиллах журмын төслийг боловсруулж эхэллээ. Мөн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын цэргийн байр, танхим, бусад барилга байгууламжийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан камерын хяналттай болгох юм.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ

ХАРЬЯА ТӨҮГ-УУДЫН

БИЗНЕС

ТӨЛӨВЛӨГӨӨГ

БАТАЛЛАА



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өчигдөр Батлан хамгаалах яамны харьяа Төрийн өмчит үйлдвэрийн газруудын бизнес төлөвлөгөөг баталлаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Батлан хамгаалах яамны харьяа Төрийн өмчит үйлдвэрийн газруудыг эрчимтэй хөгжүүлэх, үр ашигтай

байлгах, сахилга, зохион байгуулалт, байгууллагын зохих стандартыг хангаж ажиллахад удирдлага, шат шатны албан тушаалтнууд өндөр ач холбогдол өгөх ёстой. Засгийн газраас Төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг дэмжих чиглэлд, ялангуяа үр ашигтай байлгах талаар онцгой анхаарч байгаа”

гэв. Мөн Төрийн өмчит үйлдвэрийн газруудын хувьд тухайн салбарынхаа хөгжилд хувь нэмрээ оруулдаг, өөрийн гэсэн орон зайтай байх ёстой зэрэг шаардлага тавигддаг учраас дээрх чиглэлд ахиц, дэвшил гаргаж ажиллах нь чухал гэдгийг Батлан хамгаалахын сайд онцоллоо.

Төгсгөлд нь сайд Г.Сайханбаяр өмнөх онд хүрсэн түвшин, ажлын гүйцэтгэлээ улам ахиулж, үйл ажиллагаагаа чанаржуулан, иргэдэд хүрэх үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох зэрэг асуудлаар тодорхой үүрэг, чиглэл өгч удирдлагуудад ажлын амжилт хүссэн юм.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛОВ

Зэвсэгт хүчний Жанжин штабын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн 2021 оны нэгдүгээр улирлын тайлангийн хурал 4 дүгээр сарын 6-ны өдөр боллоо. Тайлангийн хуралд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлагын бүрэлдэхүүн цахимаар оролцов.

Энэ үеэр салбар зөвлөлийн гишүүн бүр санал хэлж, анхаарах асуудлын талаар байр сууриа илэрхийллээ. Тухайлбал, Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр “Цэргийн тангараг өргөсөн л бол та Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөх үүрэгтэй. Олон зуун жилийн дайчин замнал, түүхтэй салбарынхаа нэр хүндийг сэвтээх эрх та бидэнд байхгүй. Бүрэлдэхүүндээ тавих хяналтаа сайжруул, тавигдах шаардлагаа өндөрсгө” гэсэн бол ЗХЖШ-ын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа цэргийн алба хаагчдыг цахим сүлжээнд зарцуулж байгаа цагийг багасгаж, өөрийгөө хөгжүүлэхэд нь анхаарах, мөн

нэгнийхээ сэтгэл зүйн байдлыг нь хурдтай мэдэрч чаддаг байх талаар санал хэлэв. Мөн Ажиллагааны удирдлагын газрын даргын орлогч, хурандаа Д.Дугаррагчаа цар тахлын халдвараас бие бүрэлдэхүүн төдийгүй тэдний ар гэрийнхнийг Улсын Онцгой комиссын шийдвэр, зөвлөмжийг ягштал мөрдүүлэхэд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлага идэвх санаачилгатай байгаа, энэ эрчээ цаашид хадгалж ажиллахыг захилаа.

Хурлын төгсгөлд Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн дарга, хурандаа Ц.Жавхланбаатар үүрэг, чиглэл өгсөн юм. Тэрээр “Нэгдүгээрт, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь ганцхан ангийн удирдлагуудын хийх ажил биш. Үүнд алба хаагч бүрийн оролцоо чухал. Хэдий бид нийгмийн том салбар ч гэсэн хүн бүр хичээвэл зөрчил, дутагдалгүй болж чадна. ЗХЖШ-ын бүтцэд Цэргийн албаны хэлтэс шинээр байгуулсан нь алба хаагчдынхаа сахилга бат, дэг журмыг дээшлүүлэхэд гол анхаарлаа



хандуулж ажилла. Удахгүй цэргийн цагдаагийн бүлгийг нэгтгэл, анги бүрт томилгоожуулж ажиллуулахаар төлөвлөж байна. Нөгөө талаас тухайн нэгтгэл, ангийн сахилгын зөрчилгүй хамт олон болоход ихээхэн үүрэг оролцоотой алба хаагч бол яахын аргагүй хуулийн офицер. Нуулгүй хэлэхэд хуулийн офицерууд захирагчийнхаа гаргаж байгаа тушаалыг хуульд нийцүүлэх бичиг цаасны ажлаас илүү гарахгүй байна. Угтаа “Ахлагч Батаа та замын хөдөлгөөний дүрэм

зөрчөөл ийм, ийм хариуцлага хүлээнэ” гэх зэргээр бүрэлдэхүүнийхээ хуулийн мэдлэгийг дээшлүүлэхэд илүү их анхаарч ажилламаар байна. Хоёрдугаарт, орон нутгийнхаа хуулийн байгууллагуудтай нягт хамтарч ажилла. Гуравдугаарт, дотоод хяналт шалгалтаа дээшлүүл. Гэмт хэрэг, осол зөрчлөөс бүрэлдэхүүнээ сэргийлж ажилла” гэсэн үүргийг Төрийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлагад өгсөн юм. **Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА**

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
+12	-2
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
+34	+24
АФГАНИСТАН	
Өдөр	Шөнө
+16	+3

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.00	2,856.00
EUR	3,338.00	3,398.00
CNY	432.50	436.60
RUB	36.80	38.30
JPY	25.56	26.05
KRW	2.45	2.58

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 26
2021.04.07.
/ЛХАГВА ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД
ЦАГААЧИН ТУУЛАЙ
САРЫН НЭГ ЦАГААН
ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Жаргал үргэлжид ирнэ

Наран урга, шингээ:

06.18-19.30

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Шороо.

Аргын тооллын 4 дүгээр сарын 7, Буд гараг. Билгийн тооллын 26, Тооно одтой, хөхөгчин тахиа өдөр. Өдрийн наран 6 цаг 18 минутад мандан, 19 цаг 30 минутад жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэрээх, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН
831

НИЙТ БҮРТГЭГДСЭН
11651

ЭДГЭРСЭН
6010

НАС БАРСАН
17

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНӨЛӨГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН
43

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
281

ЭДГЭРСЭН
1258

НИЙТ БАТЛАГДСАН
1545

МУ-ын хэмжээнд 04 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар нийт 466942 (22,8%) иргэн Ковид-19 эсрэг вакцины эхний тунд хамрагдлаа.

Нийслэлд нийт 403162 иргэн Орон нутагт нийт 63784 иргэн

ХИЛИЙН ЧАНАДААС

МОНГОЛ ЦЭРГҮҮД ӨМНӨД СУДАНЫ ИРГЭДИЙН АМЬ НАСЫГ АВАРЛАА

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн мотобудлагын батальоны холын эргүүлийн 3 дугаар ээлжийн бүлэг "Юнити" секторын "Маёом" сууринд 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс үүрэг гүйцэтгэж байна. Тус бүс нутагт орон нутгийн зэвсэгт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, малын хулгай, дээрэм зэрэг гэмт хэргийн гаралт нэмэгдэн, цагийн байдал хурцдаж байгаа юм.

Тухайлбал, энэ сарын 03-ны шөнө "Маёом" сууринаас 20 гаруй километр орших "Боуда" тосгонд зэвсэглэсэн этгээдүүд үхэр хулгайлах зорилгоор иргэд рүү халдлага үйлдэж, буудалцаан боллоо. Энэ үеэр зэвсэгт дээрэмчдээс дөрөв, халдлагад өртсөн энгийн иргэдээс 23, нийт 27 хүний амь үрэгдэж, 25 хүн шархадсан байна. Шархадсан иргэдийн ихэнх нь 6-22 насны хүүхэд, эмэгтэйчүүд байжээ.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байсан Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид тухайн хэргийн газар цаг алдалгүй очиж, орон нутгийн эмч нартай хамтран шархадсан иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн, "Манкиен" суурин дахь хүмүүнлөгийн эмнэлэг рүү зөөвөрлөсөн юм.

Эмнэлгийн яаралтай тусламж



болон шархтан татан гаргах ажиллагааг богино хугацаанд зохион байгуулж, олон хүний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалсан монгол цэргүүдэд "Маёом" суурины дарга Хон Жеймс Чуол Гатлуак "Цагийн байдлын тогтворгүй энэ үед манай сууринд холын эргүүлийн үүрэг гүйцэтгэж байхдаа олон иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хангахад томоохон

дэмжлэг үзүүлсэнд баярлалаа" хэмээн талархал илэрхийллээ.

Олон иргэний амь насыг хохироосон зэвсэгт дээрэмчдийн эсрэг болон хулгайлагдсан 9500 үхрээ буцаан авахаар 5000 гаруй орон нутгийн иргэд тухайн бүс нутагт цуглараад байгаа тухай албан бус мэдээлэл байна.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

ГАЛЫН АЮУЛААС ҮҮДЭЛТЭЙ БЭРТЭЛ, ГЭМТЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ШИНЖ ЧАНАР, АНХНЫ ТУСЛАМЖИЙН АРГА ХЭМЖЭЭ

1. Түлэгдэлт

Галын дөл, хэт халуун шингэн, халуун уур, химийн бодис, цахилгаан гүйдэл, цацраг туяа гэх мэт хүчин зүйлийн нөлөөллөөр арьс болон арьсан доорх өвхөн эд, эрхтэн гэмтэхийг түлэгдэлт гэнэ. Шалтгаанаар нь ангилж үзвэл:

-Дулааны (халуун шингэн, улайссан хатуу биет, галын дөл, халуун уур гэх мэт)

-Химийн (хүчил, шүлт, хүнд металл гэх мэт)

-Туяаны (хэт ягаан туяа, рентген туяа, атомын цацраг туяа гэх мэт)

-Цахилгааны (аянга, цахилгаан гүйдэл)

-Холомгог Дулааны түлэгдлийг гүнээр нь үндсэн 4 зэрэгт хуваадаг.

-I зэрэг. Арьс тод улаан өнгөтэй болж хавдана.

-II зэрэг. Тунгалаг, цайвар шаравтар шингэн бүхий цэврүү үүснэ.

-III зэрэг. Арьсны өнгөн давхарга бүхэлдээ үхжсэн байна. Арьсны бүх давхарга гэмтэж үхжсэн байна.

-IV зэрэг. Хальс, өөхлөг шөрмөс, булчин, яс хүртэл гэмтэж үхжинэ.

Түлэгдэлтийн аюултай эсэх нь:

-Түлэгдэлт юунаас болж үүсэв (галын дөл, химийн бодис гэх мэт)

-Хаана түлэгдсэн (толгойд, хөлд гэх мэт)

-Хэр талбай хамарсан

-Түлэгдсэн хүний нас (хүүхэд, том хүн)

-Түлэгдсэн хүний эрүүл мэндийн байдал (хэвтрийн, архаг өвчтэй хүн) зэргээс хамаарна.

Түлэгдэлт нь хэр зэрэг талбайг хамарснаас шалтгаалж, 9-ийн тооны дүрмийг баримтална. 9 тооны дүрэм гэдэг нь насанд хүрсэн хүний гарын алгыг 1% гэж үзээд түлэгдэлтийн хэмжээг тогтоохыг хэлнэ. Насанд хүрсэн хүн 25-30%, хүүхэд 10-15% түлэгдсэн тохиолдолд шоконд орох эрсдэлтэй.

Шинж тэмдэг

Түлэгдэлтийн үед арьсан дээр илрэх дээрх өөрчлөлтүүдээс гадна их хэмжээний талбайг хамарсан тохиолдолд дараах шинж тэмдгүүд илэрнэ.

-Судасны лугшилт олширно. (1 минутад 80-аас дээш)

-Амьсгалын тоо олширно. (1 минутад 20-оос дээш)

-Арьсны өнгө цайж, ам хамрын гурвалжин хөхөрнө.

-Толгой эргэнэ.

-Дотор муухайрна.

-Огиулна.

-Бөөлжинө.

-Ам хатна.

-Ухаан санаа өөрчлөгдөнө.

Түлэнхий өвчнийг эмнэл зүйн шинжээр нь дараах 4 үе болгож үзнэ. Үүнд:

-Түлэнхийн шок -Цусны бичил эргэлтэд өөрчлөлт гарна. Шээсний хэмжээ багасна. (1-3 хоног)

-Хурц хордлогын үе-Цусны эргэлтийн үйл ажиллагаа сайжрахын

хамт нөгөө талаас цусанд хорт бүтээгдэхүүн орж, хордлого үүсгэнэ. Уураг, хлор багасаж, шингэн их алдана. (3-14 хоног)

-Халдвар хордлогын үе-Түлэгдэлтийн 7-10 дахь хоногуудад түлэгдэж гэмтсэн арьсны өнгөн үхжсэн хэсэг унаж, шарх ил болно. (14-өөс дээш хоног)

-Эдгэрэх үе-Эмчилгээний үр дүнгээс хамаарна. Эхний 3 үеийн туршид гарсан өөрчлөлтүүд аажмаар сэргэнэ. Хүнд тохиолдолд (2-4 жил)

Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж

Аль ч хэлбэрийн түлэгдэлтийн үед анхны тусламжийн зарчим нь:

-Хамгийн эхэнд тусламж үзүүлж буй хүн өөрийн аюулгүй байдлыг хангасан байх.

-Голомтоос холдуулах, түлж байгаа зүйлийг биеэс зайлуулна.



-Урсгал хүйтэн усаар 10-25 минут угаах, химийн түлэгдлийн үед 20-30 минут тасралтгүй усаар угаана.

-Нүдэнд орсон бол эрүүл нүд дээр байрлахаар угаана.

-Цэвэр боолт хийнэ.

-Бие барьсан хувцас, эд зүйлсийг яаралтай тайлж авна. (Бөгж, цаг, бүс гэх мэт)

-Өвдөлт намдаах эм тариа хийж болно. (Аналгин, арьсан доор 2 хувийн промедолын уусмал 1 мл тарина)

-Эмнэлгийн байгууллагад яаралтай хандана.

Хориглох зүйл

-Түлэгдсэн хэсэг дээр цас, мөс тавих

-Түлэгдсэн хэсэгт үүссэн цэврүүг хагалах

-Түлэгдсэн хэсэгт наалдсан хувцсыг хуулах

-Түлэгдсэн хэсэг дээр хөвөн материал тавих

Түлэнхийн боолт:

- Химидин 0,5%

- Тамедин 0,75%

- Фурациллин 1: 5000

- Панкиспины тос

- Анестезинтэй тос

- Чацарганын цэвэр тос, вазелин, антибиотикийн холимог ариутгасан тос

- Мөнгөжүүлсэн тос

- Фламмазин

2. Угаартах

Гал түймрээс үүссэн утаа, хорт хийнд хүний амьсгал боогдох, амьсгалах боломжгүй болох, улмаар үхлийн аюулд хүргэх ч эрсдэлтэй. Утаа, хийгээр амьсгалсан хүн угаартаж, хорддог. Угаартах үеийн шинж тэмдэг:

- Толгой эргэх, өвдөх

- Бие сулрах, чих шуугих

- Бөөлжих

- Амьсгал боогдох, ухаан алдах гэх мэт.

Эдгээр шинж тэмдэг илрэхэд өвчтөнд яаралтай тусламж үзүүлэхгүй бол амь насанд аюултай. Ахуйн хэрэглээнд элбэг байх болсон баллонтой хийг ашиглах, хадгалах дүрмийг баримтлаагүйгээс хийнд хордох явдал их гардаг. Хий нь өнгө, үнэргүй учир алдагдаж байгаа нь төдийлөн

мэдэгддэггүй. Иймд хийн алдагдлыг хэмжих багажийг суурилуулах нь зүйтэй.

Угаартсан хүнд анхны тусламж үзүүлэхдээ:

-Утаа, хий бүхий өрөө тасалгаа, орчноос угаартсан хүнийг яаралтай гаргах

-Хордсон өрөө тасалгаа, орчны цонх, хаалгыг онгойлгож, цэвэр агаар оруулах

-Угаартсан хүнд тайвшруулах эм уулгах (валерин гэх мэт)

-Угаартсан хүн ухаан алдсан болон амьсгалахад хүндрэлтэй байвал яаралтай эмнэлгийн тусламж дуудах, эмчийг иртэл нь өвчтөнд хиймэл амьсгал хийх

-Ахуйн хийнд хордож угаартсан хүнд тусламж үзүүлэхдээ хувцасны товчийг тайлж амьсгалах замыг чөлөөлөх, толгойд нь хүйтэн жин тавих, спирт үнэртүүлэх, цээжинд иллэг хийх, хөлийг цээжнээс өндөр түвшинд байлгах арга хэмжээг авна.

-Өвчтөний амьсгал удаахрах, тасалдах (минутад 8-аас доош удаа амьсгалах) үед яаралтай хиймэл амьсгал хийх шаардлагатай.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

ЦАГ ҮЕ

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРОО ХУРАЛДАЖ, "ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ" ТОГТООЛЫГ БАТАЛЛАА

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо 4 дүгээр сарын 6-нд төрийн цэргийн байгууллагад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, "цэргийн дэг" нэрийн дор хугацаат цэргийн алба хаагчдыг дарамтлах, эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулах зүй бус үйлдлүүд удаа дараа гарч байгаа асуудлыг хэлэлцлээ.

Дэд хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ХЭҮК-ын гишүүн Б.Энхболд, Зэвсэгт

ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, цэргийн жинхэнэ албан хаагч болон цэргийн бэлтгэл алба хаагчийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд мэдээллийг шуурхай авах, мэдээлэгчийн нууцыг чандлан хамгаалах, хадгалах тогтолцоог боловсронгуй болгох, зөрчилдсөн эрхийг сэргээн хэрэгжүүлэх, гэм хорын хохирлын нөхөн олговрын зохицуулалтыг тодорхой болгож, гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлагыг



хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир, Дотоодын цэргийн штабын орлогч, Харуул хамгаалалтын хэлтсийн дарга, хурандаа Д.Рэнцэндорж, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор Ж.Ариунаа нар оролцсон юм.

Дээрх хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, ажлын хэсгээс хариулт мэдээлэл авсны дараа "Зөвлөмж, чиглэл өгөх тухай" дэд хорооны тогтоолын төслийг Б.Энхбаяр гишүүн танилцуулав. Төрийн цэргийн байгууллагад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хугацаат цэргийн алба хаагчдыг "цэргийн дэг" нэрийн дор дарамтлах, эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулах зүй бус үйлдлүүд удаа дараа гарч байгааг хэлж, цагдаагийн хурандаа Д.Рэнцэндорж, Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг хууль, тогтоомжуудад хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эдгээрт үндэслэн эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор холбогдох төслүүдийг 2021 оны хаврын

чангатгахыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга болон Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгохоор төсөлд тусгажээ. Түүнчлэн удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалтын чиглэлээр талуудын оролцоо бүхий ажлын хэсгийг байгуулж зүй бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр богино, дунд, урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг яаралтай боловсруулж, ажиллах, өмнө гарсан тохиолдлуудын шийдвэрлэлтийн талаар олон нийтэд ил тод мэдээлэх, салбарын хэмжээнд, бүх шатанд хүний эрхийн талаарх сургалт зохион байгуулах зэргийг чиглэл болгохоор Дэд хорооны төсөлд тусгасан байна.

Дэд хорооны тогтоолын төслийн танилцуулга, хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баярсайхан, Ц.Сэргэлэн, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нар үг хэлж, байр сууриа илэрхийлэв. Дараа нь Хүний эрхийн дэд хорооны "Зөвлөмж, чиглэл өгөх тухай" тогтоолын төслийг батлах санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон 6 гишүүний 5 нь дэмжлээ.

Эх сурвалж: УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮНДЭСНИЙ БАЯЛАГ

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа энэ сарын 1-ний өдрөөс улс орон даяар эхэлсэн. Нийслэл, 21 аймгийн Статистикийн газруудад Үндэсний статистикийн хороо болон хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс чиглэл өгч ажиллаж байгаа бөгөөд төрийн албан хаагч та бүхэн нэвтрэх нэр, нууц кодоо ашиглан хаа байгаа газраасаа цахимаар судалгаанд хамрагдах боломжтой.

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлсноор үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай

хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангаж төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах, цаашид үндэсний бичгийг төрийн бүх шатанд нэвтрүүлэхэд гол баримжаа болох аж. Иймээс судалгаанд хамрагдах төрийн албан хаагчид "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим систем"-д байгаа төрийн бүх шатны байгууллагын албан хаагч төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд идэвхтэй хамрагдахыг уриалж байна.

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхний "Соёмбо" сонины редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029